Төсөл

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны .... сарын .... өдөр Дугаар ..... Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Журам батлах тухай” 450 дугаар тогтоолоор батлсан “Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг, тэтгэвэр олгох журам”-ын 2.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/2.6 дахь хэсэг:

“2.6.Даатгуулагч хуримтлалд үндэслэсэн аргаар тэтгэвэр тогтоолгох бол Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд заасан тэтгэврийн мөнгөн хуримтлалын эцсийн үлдэгдэл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэгт заасан журмыг баримтална.”

2.Энэ тогтоолыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ